



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 744

Улаанбаатар хот

Г Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн санхүүжилтээр бий болсон, 12 нэрийн, нийт 40,803,864,187.00 (дөчин тэрбум найман зуун гурван сая найман зуун жаран дөрвөн мянга нэг зуун наян долоо) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх;

2.3. Хөрөнгийн давхар бүртгэлийг залруулах;

2.4. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

• 132002935

31-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 12.дугаар сарын 16.ны өдрийн
7.чч. дугаар тоотоолын хавсраалт
ТӨВИЙН ХӨРӨНГӨӨР ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл арга хэмжээний нэр	Ашиглалтад орсон он	Гүйцэтгэгчийн нэр	Үйцэтгэлээрх хөрөнгийн дүн	Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, ашиглагч байгууллага
1	Сумын төвийн хатуу хүчинлэгтай авто зам /Баян-Өлгий, Улаанхус сум/	2022.10.01	Жол ХХК	4,289,663,414.00	Баян-Өлгийн ЗДТГ
2	Бетон гүүр 24 у/м /БӨ, Улаанхус сум/	2023.11.11	Грандрөүд ХХК	994,628,840.00	Баян-Өлгийн ЗДТГ
3	Сумын төвийн хатуу хүчинлэгтай авто зам 3, 3 км /БӨ, Алтанцэгц сум/	2024.09.18	Грандрөүд ХХК	3,454,992,724.00	Баян-Өлгийн ЗДТГ
4	Сумын төвийн хатуу хүчинлэгтай авто зам, явган хүний зам, гэрэлт, ШС, 2,3кам /БӨ, Толбо/	2023.09.06	Жол ХХК	2,971,051,227.00	Баян-Өлгийн ЗДТГ
5	Сумын төвийн хатуу хүчинлэгтай авто зам /БӨ, Алтай сум/	2023.11.03	Грандрөүд ХХК	2,488,216,285.00	Баян-Өлгийн ЗДТГ
6	Үүрхай, Сагсай сум хүртэлх авто зам, Гэрэлтүүлэг, 1,6км	2023.09.06	Жол ХХК	1,826,906,554.00	Баян-Өлгийн ЗДТГ
7	Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хүчинлэгтай авто зам	2023.11.03	Дорноговь АЗЗА	3,664,973,022.00	Дорноговь ЗДТГ
8	Сумын төвийн хатуу хүчинлэгтай авто зам /Ховд, Алтай сум/	2023.12.21	Өсөн дэвжих зам ХХК	1,048,461,945.00	Ховд ЗДТГ

9	Чоно харайх голын гүүр /Ховд, Дөргөн сум/	2022.09.02	Хотгор зам ХХК	1,622,141,933.00	Ховд ЗДТГ
10	Гудамж төсөл /Завхан, Улаастай сум/	12/13/2022	Төгс зам ХХК	9,973,534,162.00	Завхан ЗДТГ
11	Нисэх буудлын авто замын уулзвараас сумын төв хүртэлх авто зам, 6.7 км, сумын төвийн хатуу хүчилттай авто зам /Завхан, Алдархаан сум/	2022.07.04	Тэргүүн саруул зам ХХК	5,388,306,087.00	Завхан ЗДТГ
12	Баруун-Урт хотын 1 дүгээр баг, Цэргийн анги, ахмадын амралт, сувилал орчмын хэсэгчилсэн авто зам, 3.03 км /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2022.05.20	Монгол зам групп ХХК	3,080,987,994.00	Сүхбаатар ЗДТГ
				40,803,864,187.00 (Дөчин тэрбум найман зуун гурван сая найман зуун жаран дөрвөн мянга нэг зуун наян долгоо)	
				Нийт дүн	

